



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/192

Хэрлэн сум

Мал, амьтны гоц халдварт өвчинтэй  
тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2022 оны 2 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалт нэмэгдэх эрсдэлтэй байгаа тул уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж, тэмцэх бэлэн байдлыг хангаж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Улсын Онцгой комиссын 02 тоот тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг биелүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

3.Гоц халдварт шүлхий өвчин гарсан сумдын өвчилсөн малын тэмдэг тэмдэглэгээнд хяналт тавин ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ)-т, иргэдийн орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих, дэг журам, хорио цээрийн дэглэмийг сахиулахыг Цагдаагийн газар (хурандаа Д.Батхүү)-т тус тус үүрэг болгосугай

4.Баян-Адарга суманд гарсан шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, дээрх ажлын хэсгийн үйл ажиллагааны зардалд шаардлагатай хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлж эхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт гавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
09 дүгээр сарын 14 өдрийн А/192  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн  
ахлагч:

Н.Анхбаяр

Мал эмнэлгийн газрын дарга

Гишүүд:

Л.Алтанбагана

Мэргэжлийн хяналтын газрын Мал,  
эмнэлгийн хяналтын улсын байцаагч

Цагдаагийн газраас 6 алба хаагч

Онцгой байдлын газраас 3 алба хаагч

Ч.Ганпүрэв

Жолсоч

Аймгийн Засаг даргын 2022 оны  
 04 дүгээр сарын 14 өдрийн А/192  
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Баян-Адарга суманд гарсан мал, амьтны гоц халдварт  
 өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхэд гарах зардал

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Ямар байгууллагаас	Хүний тоо	1 өдрийн хоолны зардал	Хоног	Нийт зардал	Тайлбар санхүүжилт
Нэг. Ажиллах албан хаагчдын зардал							
1	Одоо байгаа 5 постон дээр нэмж 3 нийт 8 пост ажиллуулах	Онцгой байдлын газраас	3	20000	7	420000	Аймгийн онцгой комисс
		Цагдаагын газар	6	20000	7	840000	
		Сумаас	3	20000	7	420000	
2	Аймгийн онцгой комиссын шийдвэрээр тус суманд ажиллах хүн	Мал эмнэлгийн газар	2	20000	4	160000	
		Мэргэжлийн хяналтын газар	1	20000	4	800000	
Нийт			15			1920000	
Хоёр. Аймгийн ажлын хэсэг тухайн сумын нутаг дэвсгэрт ажиллах автомашины шатахуун							
	Шаардагдах зүйл	Марк	100 км-т норм	Хэдэн км	1 литр бензин үнэ	Нийт	
3	Авто машины шатахуун	Фермер	18	1000	2520	453600	
Нийт						2373600	